

МОНГОЛЫН ВОЛЕИБОЛЫН ХОЛБООНЫ  
ЕВРОП ДАХЬ САЛБАР ХОЛБООНЫ  
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 27 НЫ  
БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭЖ, ШИНЭЧЛЭН БАТЛАВ.

**МОНГОЛЫН ВОЛЕИБОЛЫН ХОЛБООНЫ САЛБАР ХОЛБОО  
ЕВРОПЫН МОНГОЛЧУУДЫН ВОЛЕИБОЛЫН ХОЛБООНЫ  
ДҮРЭМ**

**1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Европын Монголчуудын волейболын Холбоо /цаашид ЕМВХ гэнэ/ нь Европд амьдарч, суралцаж буй монголчууд дунд волейболын спортыг хөгжүүлэх зорилго бүхий волейбол сонирхогч, дэмжигчдийг нэгтгэсэн "Нийгэмд үйлчилдэг" төрийн бус байгууллага мөн.

**1.2. Оноосон нэр**

Монголоор: " Европын Монголчуудын Волейболын Холбоо" НҮТББ

Англиар: "Mongolian Volleyball Association in Europe" NGO

**1.3. Хаяг: Бельгийн Хаант улс Kingdom of Belgium,**

Petit-Rechain, 4800, rue de Gelée, Post box №7

И-мэйл хаяг: euromongovolley@gmail.com

1.4. Энэхүү ЕМВХ нь 2019 оны 1 дүгээр сарын 12-ний өдөр Монголын Волейболын холбооны Европ дахь салбар гишүүн Бельгийн Монголчуудын Сүлд холбооны санаачлагаар үүсгэн байгуулагдсан болно.

1.5. ЕМВХ нь Монголын Волейболын Холбооны албан ёсны салбар холбоо байж тус холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл, дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.6. ЕМВХ нь нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлтэй, өөрийн өмчтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээх хуулийн этгээдийн эрх зүйн чадамжтай байна. ЕМВХ нь өөрийн бэлгэдэл, тамга тэмдэг, лого, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна. ЕМВХ нь үйл ажиллагаагаа сурталчлан таниулах хэвлэлтэй байж болно.

**2. ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

2.1. ЕМВХ нь Европ дахь монголчууд болон өсвөр үеийн хүүхэд залуусыг волейболын спорт руу уриалан дуудах уг спортоор хичээллэх сонирхол төрүүлэх Европын монголчууд спортоор нөхөрлөж ойртон танилцаж бие биенээсээ харилцан суралцах боломж бурдэх Европын болон цомын тэмцээнүүд зохион явуулах улс орнуудын дундын гүүр болон ажиллана.

2.2. Европын монголчуудаа спортын талбарт ойртон танилцуулж, волейболын спортоор хичээллэх сонирхол төрүүлэх, хүүхэд залуусыг уриалан дуудах, олж

сурвалжилж баг тамирчдыг бүрдүүлэх, улс орнуудын спорт клуб, холбоод, төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоож, нэгдсэн мэдээ мэдээллээр хангах, тэмцээн уралдаан зохион байгуулах, харилцан суралцах, нэгдсэн удирдлагаар чиглүүлэх болон биеийн тамир спортыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах нь холбооны гол зорилго юм.

- 2.3. ЕМВХ нь волейболын спортыг сурталчилж, Европын монголчуудын волейболын аварга шалгаруулах тэмцээнийг өргөжүүлэн чанаржуулж улам боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, өндөр ур чадвартай тамирчид бэлтгэх ажлуудыг зохион байгуулах замаар үндсэн зорилгоо хэрэгжүүлнэ.
- 2.4. Олимпийн хөдөлгөөнийг дэмжиж, Монголын волейболын холбоо болон олон улс, тивийн волейболын Холбоодтой хамтын ажиллагааны идэвхтэй үйл ажиллагаа явуулж тэдний дэмжлэг туслалцааг авна.
- 2.5. ЕМВХ үйл ажиллагаанд Монгол улсын хууль тогтоомж, Европын холбооны улсуудын хууль журам болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.
- 2.6. ЕМВХ нь өөрийн гишүүчлэлтэй, үйл ажиллагаагаа хараат бус бие даасан байдлаар, олон нийтэд нээлттэй ил тод явуулна.

### 3. ГИШҮҮНЧЛЭЛ

- 3.1. Энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрсөн волейбол сонирхогч, дэмжигч Монгол улсын болон гадаадын харьят иргэд, байгууллага, баг хамт олон гишүүн байж болно.
- 3.2. ЕМВХ -ны үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд онцгой туслалцаа үзүүлсэн холбооны гишүүн, гадаад дотоодын иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг холбооны хүндэт гишүүнээр сонгож болно. Хүндэт гишүүн, гишүүний хураамж төлөхгүй, саналын эрх эдлэхгүй.
- 3.3. ЕМВХ -нд гишүүнээр элсэхийг хүссэн хувь хүн, байгууллага, клубүүд нь Удирдах зөвлөлд өргөдөл болон бусад бичиг баримтыг бүрдүүлснээр элсэнэ. Гишүүнээр элсүүлэх асуудлыг Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.
- 3.4. Гишүүнээс гарах хүсэлт гаргасан буюу эсвэл гишүүн энэхүү дүрмийн шаардлагыг зөрчсөн бол уг асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

### 4. ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. ЕМВХ -ны дүрмийг сахиж, үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцох үүрэгтэй.
- 4.2. Гишүүн нь Чуулган, Удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.
- 4.3. Суугаа орондоо явагдаж байгаа тэмцээн болон Европын монголчуудын волейболын аварга шалгаруулах тэмцээнд баг бүрдүүлэн оролцох бэлтгэл сургууль хийхэд идэвхтэй туслаж дэмжих үүрэгтэй.

- 4.4. Энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрч, гишүүд удирдах зөвлөлөөс тогтоосон тухайн жилийн гишүүнчлэлийн татварыг тогтоосон хугацаанд төлөх үүрэг хүлээнэ.
- 4.5. Явуулж буй үйл ажиллагаанд эрх тэгш оролцох, мэдээлэл авах эрхтэй.
- 4.6. ЕМВХ -ны хурлаар хэлэлцэх асуудалд хүсэлт гаргах, санал оруулах, аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд ажил хэрэгчээр идэвхтэй оролцох эрхтэй.
- 4.7. ЕМВХ -ны удирдах зөвлөлд сонгох, сонгогдох эрхтэй.

## 5. ТАВДУГААР ЗҮЙЛ. ЕМВХ -НЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. ЕМВХ нь бие даасан хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулах эрхтэй
- 5.2. Волеиболын спортыг хөгжүүлэх, тэмцээн уралдаан зохион байгуулах талаар МВХ болон бусад холбогдох байгууллагуудад санал хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлэх эрхтэй.
- 5.3. Мэргэжлийн багш дасгалжуулагч урьж хамтран ажиллах мэргэжлийн арга туршлага зөвлөлгөө авах эрхтэй.
- 5.4. Европын Монголчуудын волеиболын аварга шалгаруулах тэмцээнд тогтмол оролцож, удаа дараа амжилт гаргасан тамирчдыг Монгол улсын спортын зэрэг цолд дэвшүүлэн уламжлах эрхтэй.
- 5.5. Европын монголчуудын волейболын аварга шалгаруулах тэмцээнийг өргөжүүлэн чанааржуулж, нэгдсэн нэг бодлогоор хангах, хяналт тавиж ажиллах, Европын монголчуудын волеиболын аварга шалгаруулах тэмцээн хэзээ хаана болохыг ярилцаж шийдвэрлэх эрхтэй.
- 5.6. Орон оронд буй гишүүд, холбоодын үйл ажиллагааг дэмжин ажиллах үүрэгтэй.

## 6. ЗУРГАА. ЕМВХ -НЫ ЧУУЛГАН

- 6.1. Холбооны Чуулган нь холбооны удирдах дээд байгууллага мөн.
- 6.2. Чуулганыг жилд нэг удаа тогтмол хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд Удирдах Зөвлөлийн гишүүдийн шийдвэрээр эсвэл нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй хувийн саналаар ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.
- 6.3. Чуулганы зарыг хурал болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд зарлана. Чуулганы хуралдааныг тодорхой газарт товлон зохион байгуулахаас гадна чуулганд оролцогсод бие биенээ нэгэн зэрэг сонсож, харж, ярилцах боломжтой тохиолдолд цахим хэлбэрээр зохион байгуулж болно.
- 6.4. Чуулганаар дараах үндсэн асуудлыг хэлэлцэж тогтоол гаргана. Үүнд:
  - Холбооны Удирдах Зөвлөлийн болон Тэргүүний тайлан, зорилт.
  - Холбооны үндсэн чиглэл, дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах.
  - Холбооны удирдах зөвлөлийн гишүүд болон тэргүүнийг сонгон батлах.
  - Холбооны хяналтын зөвлөлийн тайлан

- Холбооны хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгон батлах
  - Зохион байгуулалтын асуудал
  - Бусад асуудал.
- 6.5. Чуулганд оролцох төлөөлөгчдийн тоог Удирдах Зөвлөлөөс Европын улс орнуудын төлөөллөөс тэгш хангагдсан байхаар бүрдүүлэн сонгоно.
- 6.6. Чуулганы төлөөлөгчдөөс сонгогдсон хуралдааны дарга чуулганыг удирдах ба эцсийн шийдвэр дийлэнх олонхийн саналаар баталгаажина.
- 6.7. Чуулганаар хэлэлцсэн асуудлыг чуулганд оролцож буй төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Чуулганд төлөөлөгч бүр тэгш эрхтэй оролцох ба төлөөлөгч бүр нэг саналын эрхтэй.
7. УДИРДАХ ЗӨВЛӨЛ, УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ
- 7.1. Чуулганы хооронд холбооны эрх барих байгууллага нь Удирдах Зөвлөл байна.
- 7.2. Чуулганаар Удирдах Зөвлөлийг сонгоно.
- 7.3. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.
- 7.4. Удирдах Зөвлөл 11 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 7.5. Тухайн улс орондоо идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг холбоо нийгэмлэгийн төлөөлөл болох ЕМВХ -ний гишүүдээс Удирдах зөвлөлд сонгогдох эрхтэй.
- 7.6. Удирдах зөвлөлийн гишүүдийг Чуулганы төлөөлөгчдөөс нэр дэвшүүлэн санал хураалтаар дээрх тооны хязгаарт бариулан сонгоно. Санал хураалтыг нууцаар явуулж болно.
- 7.7. Удирдах зөвлөлийн гишүүдийг хүндэтгэх шалтгаанаар чөлөөлөгдсөнийг Удирдах зөвлөлийн хурлаар баталгаажуулсан эсхүл дараагийн чуулганаар шинэ удирдах зөвлөлийн гишүүн сонгогдсоноор дуусгавар болно.
- 7.8. Удирдах Зөвлөл нь ЕМВХ -ны ойрын болон хэтийн үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөөг хэлэлцэж батална.
- 7.9. Удирдах Зөвлөл нь ЕМВХ -ны тухайн жилд мөрдөгдөх гишүүн иргэд, байгууллага, баг хамт олны хураамжийг хэлэлцэн батлана.
- 7.10. Удирдах зөвлөлөөс холбооны үйл ажиллагаатай уялдаа бүхий ажиллах мэргэжлийн албыг байгуулан чиг үүргийг тодорхойлон, хяналт тавьж ажиллана.
- 7.11. Удирдах зөвлөлөөс үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой санхүүгийн болон хэвлэл мэдээллийн алба байгуулах ажиллаж болно.
- 7.12. Удирдах зөвлөлийн гишүүд нь холбооны зорилго, хөтөлбөр, үйл ажиллагааг сайн дураар дэмжин, суугаа улс орныхоо баг тамирчид, гишүүдийг мэдээ мэдээллээр хангаж идэвхтэй ажиллана.

- 7.13. Удирдах Зөвлөлийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна. Хурлыг харилцан нэгнээ сонсох, ярилцах боломжтой тохиолдолд цахим хэлбэрээр хийж болно.
- 7.14. Тэргүүний эсхүл удирдах Зөвлөлийн гишүүдийн 50-аас дээш хувийн саналаар Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж болно.
- 7.15. Удирдах зөвлөлийн гишүүдийн 50-аас дээш хувь хуралд оролцосноор хуралдааны ирцийг хүчинтэйд тооцно.
- 7.16. Удирдах Зөвлөлийн хурлын зарыг хурал болохоос өмнө 7-гоос доошгүй хоногийн өмнө удирдах зөвлөлийн гишүүдэд мэдэгдэж, урьдчилан хэлэлцэх асуудлын жагсаалтыг боломжтой хэлбэрүүдээр илгээнэ.
- 7.17. Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, хуралд оролцогчдын олонхийн саналаар шийдвэр гаргана. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагч буюу тэргүүний саналаар шийдвэрлэнэ. Шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гарган тогтоолд тэргүүн гарын үсэг зурсаны дараа нийт гишүүдэд мэдээлнэ.
- 7.18. ЕМВХ нь санхүүгийн данстай байх бөгөөд түүнийг зарцуулах журмыг Удирдах Зөвлөл батлана.
- 7.19. ЕМВХ -ны санхүүг хууль дүрмийн дагуу хөтлөн явуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах үүрэгтэй.
- 7.20. Удирдах зөвлөлийн гишүүд нь холбооны зорилго, хөтөлбөр, үйл ажиллагааг сайн дураар дэмжин ажиллах бөгөөд ямарваа нэг цалин урамшуулал авахгүй. Харин тэдний холбооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой хувиасаа гаргасан бодит зардлыг нөхөн төлж болно.

## 8. ТЭРГҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

- 8.1. Тэргүүнийг Удирдах зөвлөлийн гишүүдээс нэр дэвшүүлж Чуулганы төлөөлөгчдөөр батлуулснаар түүний бүрэн эрх нь хангагдана.
- 8.2. Тэргүүн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх хөтөлбөрөө Чуулганы төлөөлөгчдөд танилцуулна
- 8.3. Тэргүүн нь Удирдах Зөвлөлийн дарга байна.
- 8.4. Тэргүүн өөрийн үйл ажиллагааг Ерөнхий нарийн бичгийн дарга болон Удирдах зөвлөлийн хамтын ажиллагаагаар гүйцэтгүүлнэ.
- 8.5. Тэргүүний санал болгосоор үүсгэн байгуулагч гишүүн, хүндэт гишүүн тодорхойлж болно. Үүсгэн байгуулагч гишүүн, хүндэт гишүүд удирдах зөвлөлд санал хүргэх, зөвлөх эрхтэй байна. Үүсгэн байгуулагч гишүүн, хүндэт гишүүд Удирдах зөвлөлийн хуралд саналын эрх эдлэхгүй.
- 8.6. Тэргүүн Монголд болон бусад улс орнуудад ЕМВХ -ыг бүрэн төлөөлнө.
- 8.7. Тэргүүн шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөлийг зарлан хуралдуулна.

8.8. Удирдах зөвлөлийн гишүүн дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, үйл ажиллагаанд удаан хугацаагаар оролцохгүй тохиолдолд чөлөөлөх ба нөхөн томилох саналыг Удирдах зөвлөлийн хуралд оруулах эрхтэй.

## 9. ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

- 9.1. Тэргүүний санал болгосноор эсвэл Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнээс Ерөнхий нарийн бичгийн даргыг томилно.
- 9.2. Ерөнхий нарийн бичгийн да4рга нь Удирдах Зөвлөл, Тэргүүний гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ЕМВХ -ны өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж ажиллана.
- 9.3. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүд, гишүүд, түнш байгууллагууд, тэдгээрийн төлөөлөлд мэдээлэл хүргэж, харилцаа холбоог хангаж ажиллана.
- 9.4. Санхүүгийн болон холбогдох тайлан, балансыг хуулийн хугацаанд нь гарган удирдах зөвлөлийн хуралд болон чуулганаар танилцуулах үүрэгтэй.
- 9.5. Ерөнхий нарийн бичгийн даргын үйл ажиллагааны зардал, урамшууллыг Удирдах зөвлөлийн хурлаар тогтооно.

## 10.ХӨРӨНГӨ, САНХҮҮ

- 10.1. ЕМВХ өөрийн данс, эд хөрөнгөтэй байна. Үүний эх үүсвэрийг дараахь хэлбэрээр бүрдүүлнэ:
  - Гишүүдийн татвар
  - Дотоод, гадаадын байгууллага, хувь хүний хандив
  - Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны орлого
  - Албан ёсны түншлэлийн гэрээний орлого
  - Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс болон олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө
  - Төрийн байгууллагын санхүүгийн дэмжлэг
- 10.2. Санхүүгийн бүрдүүлэлт, түүнийг зарцуулах журмыг Удирдах Зөвлөл батлана.
- 10.3. Данстай харьцах эрхийг Тэргүүн, Ерөнхий нарийн бичгийн дарга нар эдэлнэ.
- 10.4. Санхүүгийн болон холбогдох тайлан, балансыг Ерөнхий нарийн бичгийн дарга хуулийн хугацаанд нь гарган удирдах зөвлөлийн хуралд болон чуулганаар танилцуулна.

## 11. МЭРГЭЖЛИЙН АЛБА

- 11.1. Мэргэжлийн алба нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 11.2. Мэргэжлийн албыг Удирдах Зөвлөлөөс сонгоно.

11.3. Мэргэжлийн алба нь тэмцээн уралдаанд хяналт тавьж, мэргэжлийн чиг баримжаа өгч хамтарч ажиллах, тэмцээний дүрэм журмыг сахиулах мөрдүүлэхэд анхаарах, шинээр гарч байгаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг танилцуулж мөрдүүлэх сургалт семинар зохион байгуулах үүрэгтэй.

## 12.ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

12.1. Хяналтын Зөвлөл З хүний бүрэлдэхүүнтэй ажиллана. Чуулганд оролцсон төлөөлөгчид дотроос З жилийн хугацаагаар томилно. Удирдах зөвлөлийн гишүүн нь Хяналтын албаны гишүүнээр хавсрان гүйцэтгэхийг хориглоно.

12.2. Хяналтын Зөвлөл нь Холбооны гишүүд бүх шатны байгууллагын үйл ажиллагаа, төлөвлөгөөний хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавина.

## 13.БУСАД

13.1. Холбоог өөрчлөн зохион байгуулах, татан буулгах тухай асуудлыг Удирдах Зөвлөлийн саналын дагуу Чуулганаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Энэ асуудлыг Холбооны нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Чуулганы шийдвэрийг олон нийтэд мэдээллэнэ.

13.2. Хэрэв Чуулганаас Холбоог татан буулгах шийдвэр гаргасан бол холбогдох хууль тогтоомж, журмын дагуу татан буулгалтын комисс томилж, татан буулгах ажиллагааг хийх ба бусдад төлбөл зохих өр төлбөрийг гүйцэтгээд үлдсэн хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлнэ

13.3. Энэхүү дүрэм батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.